

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/28/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.umnugovi@audit.gov.mn Өмнөговь аймаг 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ДАЛАНЗАДГАД СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.БАЯСГАЛАН
ТАНАА

2022-02-22 № 97

танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Даланзадгад сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-22 №97\с

220011132

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	39.7	38.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	959.5	897.1
	Нийт хөрөнгийн дүн	999.2	935.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	657.7	935.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	657.7	935.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	598.5	394.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	480.7	458.2
	Үйл ажиллагааны үр дүн	117.8	(63.9)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	117.8	(63.9)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208.4	999.2
	Тайлант оны үр дүн	(63.9)	(63.9)
	Эцсийн үлдэгдэл	144.5	935.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	411.1	384.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	411.1	382.9
	Үйл ажиллагааны ЦМГ	-	1.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	1.3
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	373.4	348.8
	Урсгал зардал	373.4	348.8
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	373.4	348.8
	Улсын төсвөөс санхүүжих	331.7	313.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41.7	35.9

/сая төгрөгөөр/

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 2 дугаар Цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн сурах үйл, тэдний хөгжлийг дэмжихэд тулгарч буй бэрхшээлийг арилгахад хамтын оролцоог нэмэгдүүлэх, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй тасралтгүй зохион байгуулж төлөвшлийг олгон хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх” гэж зорилгоо тодорхойлсон байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, 190 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- хичээл практикийн зардлаас 1,4 сая төгрөгийн самбар худалдан авсан,
- Өндөр настны тэтгэвэрт гарсан С.Цасчихэрийг 2021-11-01-ны өдрөөс аргазүйчийн албан тушаалд буцаан томилсон байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 2 дугаар Цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 2 дугаар Цэцэрлэг нь Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад орлогын 10 гүйлгээний 217,5 сая төгрөгийн мэдээлэл, зарлагын 5 гүйлгээний 64,5 сая төгрөгийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-г мөрдөж ажиллаагүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 285,379.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 20.4 сая төгрөгийн алдааг залруулж, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 албан шаардлага өгсөн.

4.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Тус байгууллага нь Өндөр настны тэтгэвэрт гарсан С.Цасчихэрийг 2021-11-01-ны өдрөөс аргазүйчийн албан тушаалд буцаан томилсон байна.

Өгсөн албан шаардлага:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах ,

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											

1	ТШЗ	3	3,3	1	0,02	0	0	1	3,3	-	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	3	3,3	1	0,02	0	0	1	3,3	-	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	1	282,0					1	282,0		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
	НИЙТ ДҮН	1	282,0					1	282,0		